



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2019/118/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
Дорноговь аймаг, Сайншанд сум
2019 он

Тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа
Утас: 99092469 Цахим хаяг:
Аудитын менежер: Э.Энхцэцэг
Утас: 90077079 Цахим хаяг:
Аудитор: Г.Энхтөр
Утас: 96441690 Цахим хаяг:

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.
Дорноговь аймгийн Төрийн аудитын газар, Сайншанд сум, Орон нутгийн өмчийн 3 дугаар байр

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	3
2	Аудитын тайлан	5
2.1	Оршил.....	5
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	6
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	7
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	8
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	8
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	9
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	9
2.11.	Шилэн дансны мэдээлэл	10
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	10
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	10
3	Менежментийн захидал	11
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан	14

1 Аудитын гэрчилгээ



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орхи нутгийн өмчийн Ш байр,
Утас (705) 2-27-34

2019 о.д. 2.6 № 1-Б/198

Танай _____ -ны № _____ -г

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.


Зөрчилгүй санал дүгнэлт

Дорноговь аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Дорноговь аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.




Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Дорноговь аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Дорноговь аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг НДХ-ийн дарга Л.Шагдарсүрэнд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 2 дугаар сарын 20-ноос 2019 оны 2 дугаар сарын 25-ны өдрийн хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 2 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь төрийн аудитын газар хариуцаж хэрэгжүүлэв.

Дорноговь аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь төрийн аудитын газарт 2019 оны 2 дугаар сарын 19-ний өдөр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Дорноговь аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Дорноговь аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс нь даатгуулагчдад хөнгөн шуурхай мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх замаар нийгмийн даатгалын хүрээг өргөтгөх, тэтгэвэр тэтгэмж авах хуульд заасан бусад бүрэн эрхээ эдлэх нөхцлийг бүрдүүлэх гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

2006 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 01 тоот шийдвэрээр Дорноговь аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Албан журмын нийгмийн даатгалын үйл ажиллагаа

Дорноговь аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Дорноговь аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тэтгэмжийн тухай хууль
- Нийгмийн даатгалын сангийн 2018 оны төсвийн тухай хууль
- Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хууль
- Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол , мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр , тэтгэмж , төлбөрийн тухай хууль
- Эрүүл мэндийн даатгалын тухай хууль
- Эрүүл мэндийн даатгалын сангийн 2018 оны төсвийн тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

Байгууллагын үйл ажиллагааг зохицуулж байгаа эрх зүйн орчинд томоохон шинэчлэлт өөрчлөлт гараагүй

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого холбогдох дүрэм , журамд нийцсэн байна.

Дорноговь аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд эрсдэлгүй буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Дорноговь аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Санхүүгийн тооцоолох групп ХХК-ийн Acolous” програм хангамж ашигладаг байна.

Дорноговь аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт Үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Дорноговь аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 8 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 2 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Нийт зардлын 1 хувиар сонгов.

Нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь батлагдсан төсвийн дагуу зардлыг санхүүжүүлж байгаа тул үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнгээс материаллаг байдлын түвшинг тогтоосонтой холбоотой юм.

Дорноговь аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2018 оны Нийт зардал 2,475.66 мянган төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 2,475.66 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцох нь оновчтой гэж үзсэн

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 4 чиглэлээр аудитын 6 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 5 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 1 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийгээгүй.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй
асуудлыг ангилсан байдал

(Мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	5	42,998.20	
2	Төлбөрийн акт тогтоосон	0	0.00	
3	Албан шаардлага өгсөн	0	0.00	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0.00	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0.00	
	Дүн	5	42,998.20	

2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулсан бөгөөд бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудал гараагүй.

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудал гараагүй

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Дорноговь аймгийн Нийгмийн даатгалын хэлтэст чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 456,978.7 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 454,764.7 мянган төгрөг буюу 99.5 хувьтай байгаа нь цалин хөлс, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал хэмнэгдсэнээс шалтгаалжээ.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Дорноговь аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар буюу өмнөх аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Дорноговь аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Дорноговь аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Дорноговь аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. 2018 оны 12 дугаар сарын Нийгмийн даатгалын шимтгэлийн тайлангаар 24786413,69 төгрөгийн өглөгтэй байна.
2. Ажилтанд ээлжийн амралт олгох тухай мэдэгдлийг зааврын дагуу хөтөлдөггүйгээс ямар хугацаанд хамаарах ажлын жилийн ээлжийн амралтыг олгосон нь тодорхойгүй байна.
3. Бараа материалын тайлан /НХМаягт БМ-9/-г нэр төрөл үнийн дүнгээр тайлагнаагүй нийт дүнгээр гаргасан байна.
4. Сургалтын үйл ажиллагаанд гарах зардлыг урьдчилан төлөвлөсөн боловч хэмнэж болох зардлууд гарсан байна. Тухайлбал багш нарын Улаанбаатар хотоос ирж буцах зардалд автомашин хөлсөлж 900000 төгрөг, сургалтанд 80 хүн оролцсон байхад сургалтын материал 200 хүн буюу 2000000 төгрөг, номын үнэ 300 ш буюу 2400000 төгрөг тус тус зарцуулсан байна.
5. Сургалт зохион байгуулахаар 2018 оны 6 дугаар сарын 25-ны өдөр байгуулсан 01/2018 тоот гэрээний 7 дугаар зүйлд хөрөнгийн зарцуулалтын тайлан, санхүүгийн холбогдох баримт бичгийг холбогдох журмын дагуу бүрдүүлж сургалт зохион байгуулсан байгууллага НДХ-т ирүүлэхээр зааж 10000889 төгрөгийн зарцуулалтын тайлан ирүүлсэн байна. Гэвч тухайн тайланд сургалтын үйл ажиллагаанд зарцуулсан нь нотлогдохооргүй анхан шатны баримтуудыг үндэслэсэн зардлууд байна. Тухайлбал Ц.Уртнасанд 900000 төгрөг олгосон баримтгүй, багш нарын хоолны зардал гэж хувь хүний баримт болох 125489 төгрөг, сургалтанд оролцогчдын үдийн цайны зардал Е-баримтгүй 320000 төгрөг, завсарлагын цайны зардал гэж хувь хүний баримт болох 67700 төгрөг, сургалтын материал хүлээн авсан хүний гарын үсэггүй 4400000 төгрөг байна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

3.1 Балансын данстай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

2018 оны 12 дугаар сарын Нийгмийн даатгалын шимтгэлийн тайлангаар 24786413,69 төгрөгийн өглөгтэй байна.

Энэ нь эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хууль тус тус зөрчсөн байна.

3.1.2 Эрсдэл:

Санхүүгийн тайланд авлага, өглөг бүртгэсэн байх

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 , 39 дүгээр зүйлийн 39.4.2 заалтуудыг мөрдөж ажиллах

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

2019 оны төсөвт тусгаж шийдвэрлэж байгаа

3.2 Тухайн байгууллага, салбартай холбоотой хууль эрх зүйн орчин

3.2.1 Илрүүлэлт:

Ажилтанд ээлжийн амралт олгох тухай мэдэгдлийг зааврын дагуу хөтөлдөггүйгээс ямар хугацаанд хамаарах ажлын жилийн ээлжийн амралтыг олгосон нь тодорхойгүй байна.

Энэ нь үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Эрүүл мэнд , нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 166 тоот тушаалаар баталсан заавар тус тус зөрчсөн байна.

3.2.2 Эрсдэл:

Хууль журмын хэрэгжилтийг хангаагүй байх

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Ээлжийн амралт олгох тухай мэдэгдлийг Эрүүл мэнд , нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 166 тоот тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан заавар , маягтын дагуу хөтлөх нь зүйтэй

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Санал байхгүй

3.3 Балансын данстай холбоотой асуудал

3.3.1 Илрүүлэлт:

Бараа материалын тайлан /НХМаягт БМ-9/-г нэр төрөл үнийн дүнгээр тайлагнаагүй нийт дүнгээр гаргасан байна.

Энэ нь эрх ба үүрэг , иж бүрэн байдал батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар баталсан заавар тус тус зөрчсөн байна.

3.3.2 Эрсдэл:

Бараа материалын тайланг нэр төрлөөр гаргадаггүй байх

3.3.3 Өгсөн зөвлөмж:

Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар баталсан зааврын дагуу НХМаягт БМ-9 тайланг гаргах

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Архив хариуцсан ажилтан нярвын ажлыг хавсран хийдэг. Ямар нэг нэмэгдэл урамшуулал олгодоггүй.

3.4 Зардлын данстай холбоотой асуудал

3.4.1 Илрүүлэлт:

Сургалтын үйл ажиллагаанд гарах зардлыг урьдчилан төлөвлөсөн боловч хэмнэж болох зардлууд гарсан байна. Тухайлбал багш нарын Улаанбаатар хотоос ирж буцах зардалд автомашин хөлсөлж 900000 төгрөг , сургалтанд 80 хүн оролцсон байхад сургалтын материал 200 хүн буюу 2000000 төгрөг, номын үнэ 300 ш буюу 2400000 төгрөг тус тус зарцуулсан байна.

Энэ нь иж бүрэн байдал , толилуулга ба тодруулга батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хууль тус тус зөрчсөн байна.

3.4.2 Эрсдэл:

Төсвийг хэмнэлттэй зөв зарцуулаагүй байх

3.4.3 Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай , хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах" гэсэн заалтыг мөрдөж ажиллах нь зүйтэй

3.4.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Санал байхгүй

3.5 Зардлын данстай холбоотой асуудал

3.5.1 Илрүүлэлт:

Сургалт зохион байгуулахаар 2018 оны 6 дугаар сарын 25-ны өдөр байгуулсан 01/2018 тоот гэрээний 7 дугаар зүйлд хөрөнгийн зарцуулалтын тайлан , санхүүгийн холбогдох баримт бичгийг холбогдох журмын дагуу бүрдүүлж сургалт зохион байгуулсан байгууллага НДХ-т ирүүлэхээр зааж 10000889 төгрөгийн зарцуулалтын тайлан ирүүлсэн байна. Гэвч тухайн тайланд сургалтын үйл ажиллагаанд зарцуулсан нь нотлогдохооргүй анхан шатны баримтуудыг үндэслэсэн зардлууд байна. Тухайлбал Ц.Уртнасанд 900000 төгрөг олгосон баримтгүй , багш нарын хоолны зардал гэж хувь хүний баримт болох 125489 төгрөг , сургалтанд оролцогчдын үдийн цайны зардал Е-баримтгүй 320000 төгрөг , завсарлагын цайны зардал гэж хувь хүний баримт болох 67700 төгрөг , сургалтын материал хүлээн авсан хүний гарын үсэггүй 4400000 төгрөг байна.

Энэ нь үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тус тус зөрчсөн байна.

3.5.2 Эрсдэл:

Анхан шатны дэмжих баримтгүй ажил гүйлгээг бүртгэсэн байх

3.5.3 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийг мөрдөж ажиллах

3.5.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Санал байхгүй

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	15,226,583.73	11,924,756.43
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	41,107.30	3,863.42
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	41,107.30	3,863.42
31210	Төгрөг	41,107.30	3,863.42
31213	Арилжааны банк дахь харилцах	41,107.30	3,863.42
33	АВЛАГА	2,672,732.86	-
33500	Бусад авлага	2,672,732.86	-
33510	Байгууллагаас авах авлага	721,962.86	-
33520	Хувь хүмүүсээс авах авлага	1,950,770.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	12,512,743.57	11,920,893.01
35400	Хангамжийн материал	12,512,743.57	11,920,893.01
35410	Бичиг хэргийн материал	124,021.57	96,000.01
35420	Аж ахуйн материал	6,441,900.00	6,846,034.00
35430	Сэлбэг хэрэгсэл	125,600.00	-
35440	Тууш, шатах тослох материал	110,000.00	280,000.00
35450	Барилгын засварын материал	118,000.00	-
35470	Бусад хангамжийн материал	5,593,222.00	4,698,859.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	512,916,751.46	494,177,623.51
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	512,916,751.46	494,177,623.51
39100	Газар	-	-
39200	Биет хөрөнгө	512,916,751.46	468,977,623.51
39201	Барилга, байгууламж, орон сууц	429,349,044.00	351,060,639.99
39202	Хуримтлагдсан эзгдэл	(74,290,932.91)	-
39203	Авто-тээврийн хэрэгсэл	88,900,000.00	88,900,000.00
39204	Хуримтлагдсан эзгдэл	(48,040,277.78)	(60,745,833.33)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	127,563,027.00	128,268,353.00
39206	Хуримтлагдсан эзгдэл	(53,734,936.67)	(75,386,312.97)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	63,814,811.00	63,720,811.00
39208	Хуримтлагдсан эзгдэл	(20,643,983.18)	(26,840,034.18)
39300	Биет бус хөрөнгө	-	25,200,000.00
39301	Програм хангамж	5,427,586.00	5,427,586.00
39302	Хуримтлагдсан эзгдэл	(5,427,586.00)	(5,427,586.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	-	25,200,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	528,143,335.19	506,102,379.94
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	7,014,777.41	24,786,360.67
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.11	24,786,360.67
41300	Өглөг	0.11	24,786,360.67
41310	Ажирчдтай холбогдсон өглөг	0.11	24,786,360.67
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	7,014,777.30	-
42200	Урт хугацаат зээл	7,014,777.30	-
42210	Төгрөг	7,014,777.30	-
42217	Санхүүгийн бусад байгууллага	7,014,777.30	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	521,128,557.78	481,316,019.27
51	Засгийн газрын хувь оролцоо	521,128,557.78	481,316,019.27
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	366,264,211.87	366,264,211.87
51200	Хуримтлагдсан үр дүн	154,864,345.91	92,406,660.00
51210	Өмнөх үеийн үр дүн	171,086,097.61	181,163,012.97
51220	Тайланг үеийн үр дүн	(16,221,751.70)	(88,756,352.97)
51230	Давхардсан гуйлгээг цэвэрлэх данс	-	-
51300	Хөрөнгийн дахин үндэслэлийн зөрүү	-	22,643,147.40
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	528,143,335.19	506,102,379.94

4417144353
EICA0056 9825707

Дорноговь аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Төгрөгөөр

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	932,839,547.97	485,189,651.78
12	ТАТВАРЫН БҮС ОРЛОГО	2,505,864.97	16,864,441.78
120	Нийгэмт татварын бүс орлого	2,505,864.97	4,600,849.20
120002	Хүүгийн орлого	44,064.97	83,153.65
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,461,800.00	4,517,695.55
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжээж	2,461,800.00	1,263,951.55
1200045	Үнэ төлбөргүй худалдан авсан орлого	-	3,253,744.00
121	Хөрөнгийн орлого	-	12,263,592.58
121001	Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого	-	12,263,592.58
13	ТҮСЛЭМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	930,333,683.00	468,324,210.00
1311	Нөөцт санхүүжилтийн орлого	1,050,000.00	11,346,510.00
131103	БГНХ,МДНХоронго түүнтэй ашигтай ашиглагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захиралд худалдсан хөрөнгө	-	3,200,000.00
131104	Дэд шатны төсвийн захиралчийн төсөвт тусгагдаж төсвөөс дээд шатны төсвийн захиралд худалдсан хөрөнгө	1,050,000.00	7,646,510.00
1320	Төсвийн захирагчийн	17,936,583.00	-
132002	Төлөвлөгөөнд шилжүүлэг	17,936,583.00	-
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжээж	511,341,100.00	456,978,700.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжээж	511,341,100.00	456,978,700.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	549,040,299.67	548,544,168.78
21	УРСГАЛ ЗАРДАЛ	549,040,299.67	548,544,168.78
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛЭЭНИЙ ЗАРДАЛ	513,930,634.60	516,918,624.14
2101	Цалин хөлс болон нэмэгдэл үрэмшлээ	164,840,496.55	185,707,846.00
210101	Үндсэн цалин	327,413,788.55	298,605,475.00
210102	Нэмэгдэл	920,276.00	13,663,500.00
210103	Унаа хоолын хангамж	12,257,910.00	10,236,900.00
210105	Гэрээт ажилын хөлс	24,239,552.00	31,101,971.00
2102	Ажил олгогчдоос нийгмийн даатгал тусам шилжүүлэг	39,149,197.00	47,727,899.00
210201	Тэтгэврийн даатгал	24,899,016.50	28,602,055.60
210202	Тэтгэврийн даатгал	2,210,250.55	1,911,597.24
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,210,250.55	2,824,314.12
210204	Ажлынхүндийн даатгал	704,689.15	704,010.33
210205	Эрхэл мэндийн даатгал	7,124,190.25	7,062,921.70
2103	Байр ашиглалттай холбоотой тэтгэмж зардал	28,780,259.70	35,651,326.74
210301	Газал, цахилгаан	3,824,400.00	4,228,594.00
210302	Тухайн хамалт	23,961,500.00	20,066,499.65
210303	Цахил, бохир ус	1,754,359.70	1,356,233.09
2104	Хангамж, бараа материалын зардал	11,542,257.82	11,467,545.96
210401	Бичиг хэргийн	2,675,570.22	3,156,727.98
210402	Тээвэр, шатаах	4,825,000.00	3,368,530.00
210403	Шуудан, шилбүү, шилжүүлгийн төлбөр	2,757,282.60	2,259,769.00
210405	Хөгжсөөр хийгдсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	227,200.00	327,200.00
210406	Бага хэмжээт, тургэн элчлэл, ахуйн за туйлаас	937,703.00	415,299.00
2106	Эн хөнгөнд, урсгал засварын зардал	2,899,395.00	4,624,750.00
210601	Батал, техник, хэрэгсэл	211,000.00	463,000.00
210604	Урсгал засвар	2,748,395.00	4,163,750.00
2107	Төмнөлд, цочмын зардал	2,007,000.00	3,013,000.00
210701	Г адал ажил төмнөлт	-	-
210702	Дотоод ажил төмнөлт	2,007,000.00	3,013,000.00
210703	Ажлын гүйцэтгэл хурдны ажил	-	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,878,642.29	23,760,206.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийгэмт ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,797,782.29	12,905,873.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	864,000.00	900,000.00
210803	Дайтгалын үйлчилгээ	888,450.00	1,070,000.00
210804	Тээврийн хэрэгсэлийн татаар	128,020.00	143,993.00
210805	Тээврийн хэрэгсэлийн өмчлөлөг	-	-
210806	Мэдээлэл, техник хэрэгсэл үйлчилгээ	-	-
210807	Г адалын төлбөр	35,200.00	729,840.00
210808	Иван, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	99,000.00	160,000.00
210809	Улсын мэдээллийн мөхөт хэрэгсэл, бэлтгэл	66,190.00	7,850,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	53,772,686.24	49,965,050.44
210902	Хичээл үйлдвэрлэлийн зардал	1,230,000.00	730,200.00
210903	Үндсэн зориулалтын зардал, хөдөөдөг	52,542,686.24	49,234,850.44
2113	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	33,109,685.07	31,624,544.84
21132	Бусад урсгал шилжүүлэг	21,783,863.00	27,068,200.00
2113204	Ажил олгогчдоос өлгөн бусад тэтгэмж, үрэмшүүлэл	8,283,863.00	8,100,000.00
2113207	Тэтгэвэрт гарихад өлгөн нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	18,968,200.00
2113209	Нэг удаагийн тэтгэмж, шатлаа үрэмшүүлэл	12,500,000.00	-
21135	Төсвийн захирагчаас өлгөөн санхүүжилт, шилжүүлэг	11,325,802.07	4,557,344.84
2113503	Төлөвлөгөөнд шилжүүлэг	11,325,802.07	4,557,344.84
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)-(I)-(II)	116,209,751.70	103,554,937.00
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БҮС ЗАРДЛЫН ДҮН	30,000.00	30,413,855.97
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	30,000.00	3,984,489.43
225007	Хөрөнгийн дахин үйлдвэрлэлийн зардал	-	2,641,366.54
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)-(III)-(IV)-(V)	(16,221,751.70)	(88,756,322.97)

4417144353
EIOAD056 9025707

Дорноговь аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

АУДИТ ХВЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Төгрөгөөр


Код	Үгчлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНГ ОН
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	525,048,694.97	475,341,179.20
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	12,651,594.97	7,015,969.20
120	Нийтлэг татварын бус орлого	12,651,594.97	7,015,969.20
120002	Хүүгийн орлого	44,064.97	83,153.65
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	12,607,530.00	6,932,815.55
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,145,730.00	5,668,864.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,461,800.00	1,263,951.55
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	512,297,100.00	468,325,210.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,050,000.00	11,246,510.00
131103	ЗГНХ,ЗДНХ,Хөрөнгө,түүтэй адилтгах ашиглааагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захиралчид хувиарилсан хөрөнгө	-	3,700,000.00
131104	Дээд шатны төсвийн захиралчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захиралчид хувиарилсан хөрөнгө	1,050,000.00	7,646,510.00
13140	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	511,347,100.00	456,978,700.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	511,347,100.00	456,978,700.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	525,883,292.64	471,678,423.08
21	УРСГАЛ ЗАРДАЛ	525,883,292.64	471,678,423.08
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	492,772,627.57	440,057,878.44
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	382,707,085.30	331,146,860.00
210101	Үндсэн цалин	345,569,114.30	273,603,060.00
210102	Нэмэгдэл	929,176.00	13,663,500.00
210103	Уриа хоосны хөнгөлөлт	12,257,910.00	10,260,800.00
210105	Гэрээт ажлын хөлс	23,950,785.00	35,617,500.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгала төвөг шимтгэл	39,457,200.00	39,507,400.00
210201	Тэтгэврийн даатгал	25,158,379.20	26,446,253.56
210202	Тэтгэмжийн даатгал	3,243,690.40	3,267,261.98
210205	УОМШО-ний даатгал	3,243,690.40	3,611,439.14
210204	Ажилчдын даатгал	712,029.60	651,822.10
210205	Эрүүл мэндийн даатгал	7,199,410.40	6,530,573.22
2103	Байр шингэлтийг аюулгүй төгтмөл зардал	28,789,359.70	25,651,326.74
210301	Гэрээ, шилжлэл	3,324,400.00	4,228,594.00
210302	Түдн, халаалт	23,501,500.00	20,066,499.65
210303	Цэвэр, бохир ус	1,754,359.70	1,356,233.09
2104	Хяналт, бараа материалын зардал	11,496,307.60	12,002,358.40
210401	Бичиг хэрэг	2,628,720.00	3,128,706.40
210402	Тээвэр, шилжүүлэл	5,035,000.00	5,538,550.00
210403	Хос хяналт зийлүүлэх, хөдөлмөрчдийн устгал, ариутгал	2,757,282.60	2,249,769.00
210405	Бага үнэтэй, гурвал зургад, асуйн эд зүйлс	227,200.00	227,200.00
2106	Эн хөрөнгө, туслах зориоллын зардал	848,105.00	848,133.00
210601	Бэлгэ, тусламж, хэрэгсэл	3,207,994.00	4,382,150.00
210604	Урсгал засвар	236,600.00	336,400.00
2107	Төмийлөлт, зочны зардал	2,866,395.00	4,045,750.00
210702	Дотоод ажил төмийлөлт	2,007,000.00	3,013,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн өмч, үйлчилгээний төлбөр, хураамж	23,792,779.97	21,619,583.30
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн өмч, үйлчилгээний төлбөр хураамж	10,797,782.30	12,905,873.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэмгээл төгтмөл	864,000.00	900,000.00
210803	Давтгалын үйлчилгээ	888,350.00	1,070,000.00
210804	Тэтгэврийн хэрэгсэлийн татвар	128,020.00	143,993.00
210807	Газрын төлбөр	25,200.00	729,840.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	99,000.00	160,000.00
210809	Урьдчилсан мэдээллийн мөнгө хэмээх, бэлтгэх	10,980,327.67	5,709,877.10
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,230,000.00	730,200.00
210902	Хяналт үйлчилгээний даатгал хийх	1,230,000.00	730,200.00
213	УРСГАЛ ШИНГЭВЭР	23,109,665.07	31,625,544.64
2132	Бусад урсгал шинжүүлэг	21,783,863.00	27,068,200.00
213204	Ажил олгогчоос өндөр, бусад тэтгэмж, урамшуулал	8,283,863.00	8,100,000.00
213207	Гэрээт гэрээнд олох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	18,968,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж шавгал урамшуулал	13,500,000.00	-
2133	Төсвийн захирагчаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	11,325,802.07	4,557,344.64
213303	Төлбөрүүлэх шилжүүлэг	11,325,802.07	4,557,344.64
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)-(I)-(II)	(824,597.67)	3,662,736.12
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	-	3,700,000.00
52	ХӨРӨНГӨНИЙ ЗАРДАЛ	-	3,700,000.00
220	Дотоод эх үүсвэрээр	-	3,700,000.00
225106	Биет би биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	3,700,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)-(IV)-(V)	-	(3,700,000.00)
VII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VII)=(III)+(VI)-(VII)	(824,597.67)	12,243,883
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	875,704.97	41,107.30
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	41,107.30	3,863.42
100	Төлбөрүүлсэн орлого, зарлагын зөрүү	-	-

4417144353
EICA0056 9025707

АУДИТ ХИЙГДСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	366,264,211.87		171,086,097.61	537,350,309.48
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	366,264,211.87		171,086,097.61	537,350,309.48
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт				
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт				
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
7	Өмчид гарсан өөрчилөлт				
8	Зарласан ногдол ашиг				
9	Тайланг үеийн үр дүн			(16,221,751.70)	(16,221,751.70)
10	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	366,264,211.87		154,864,345.91	521,128,557.78
11	2018 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	366,264,211.87		154,864,345.91	521,128,557.78
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			26,298,667.07	26,298,667.07
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	366,264,211.87		181,163,012.98	547,427,224.85
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт		22,645,147.40		22,645,147.40
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт				
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
17	Өмчид гарсан өөрчилөлт				
18	Зарласан ногдол ашиг				
19	Тайланг үеийн үр дүн			(88,756,352.97)	(88,756,352.97)
20	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	366,264,211.87	22,645,147.40	92,406,660.00	481,316,019.27


 4417144353
 EHOA0056 9025707

Дорноговь аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

АУДИТ ХИЙГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү	Хуви
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦӨВӨР ЗЭЭЛИЙН ДҮН	456,978,700.00	454,764,691.14	2,214,008.86	99.52
21	УРСГАЛ ЗАРДАЛ	456,978,700.00	454,764,691.14	2,214,008.86	99.52
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	431,010,500.00	428,796,491.14	2,214,008.86	99.49
2101	Цалин хөлө болон нэмэгдэл урамшил	328,262,600.00	328,262,600.00	-	100.00
210101	Үндсэн цалин	268,720,800.00	268,720,800.00	-	100.00
210102	Нэмэгдэл	13,663,500.00	13,663,500.00	-	100.00
210103	Ундаа хоолны хангалалт	10,260,800.00	10,260,800.00	-	100.00
210104	Урамшуулал	-	-	-	-
210105	Гэрээт аажмын хөлө	35,617,500.00	35,617,500.00	-	100.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	39,507,400.00	39,507,400.00	-	100.00
210201	Тэтгэврийн даатгал	26,338,300.00	26,446,253.56	(107,953.56)	100.41
210202	Тэтгэмжийн даатгал	3,292,200.00	3,267,261.98	24,938.02	99.24
210203	ҮОМЦО-ний даатгал	2,633,800.00	2,611,439.14	22,360.86	99.15
210204	Ажилгүйдлийн даатгал	658,400.00	651,872.10	6,527.90	99.01
210205	Эрүүл мэндийн даатгал	6,584,700.00	6,530,573.22	54,126.78	99.18
2103	Байр ашигшантай холбоотой тогтмол зардал	26,864,100.00	25,651,326.74	1,212,773.26	95.48
210301	Гэрээ, шилжлэл	4,228,600.00	4,228,594.00	6.00	100.00
210302	Түвш, хилшилт	20,066,500.00	20,066,499.65	0.35	100.00
210303	Цэвэр, бохир ус	2,569,000.00	1,356,233.09	1,212,766.91	52.79
2104	Хангамж, бараа материалын зардал	11,501,200.00	11,500,108.40	1,091.60	99.99
210401	Бичиг зэрэг	3,128,800.00	3,128,706.40	93.60	100.00
210402	Тээвэр, шатахуун	5,036,300.00	5,036,300.00	-	100.00
210403	Шуудан, холбоо, интернетын төлбөр	2,260,700.00	2,259,769.00	931.00	99.96
210405	Хөг хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	227,200.00	227,200.00	-	100.00
210406	Балч үнэгтэй, тургэн злэгдэх, ахуйн эд зүйлс	848,200.00	848,133.00	67.00	99.99
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,388,000.00	4,382,130.00	5,850.00	99.87
210601	Баглаж, техник, хэрэгсэл	336,600.00	336,400.00	200.00	99.94
210604	Урсгал засвар	4,051,400.00	4,045,750.00	5,650.00	99.86
2107	Томиллолт, зочны зардал	2,015,100.00	2,013,000.00	2,100.00	99.90
210702	Дотоод албан томиллолт	2,015,100.00	2,013,000.00	2,100.00	99.90
2108	Бусадвар гүйцэтгүүдсэн жилд, үйлчилгээний төлбөр, хураамж	17,741,800.00	16,749,706.00	992,094.00	94.41
210801	Бусадвар гүйцэтгүүдсэн бусад нийтлэг ажла үйлчилгээний төлбөр хураамж	14,733,300.00	13,745,873.00	987,427.00	93.30
210802	Аудит, баталгаажуулалт, хэрэглээ тогтоох	900,000.00	900,000.00	-	100.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,070,000.00	1,070,000.00	-	100.00
210804	Тээврийн хэрэгсэлийн татвар	148,500.00	143,993.00	4,507.00	96.96
210807	Газрын төлбөр	730,000.00	729,840.00	160.00	99.98
210808	Банк, саяхуугийн байгууллагын үйлчилгээний хураамж	160,000.00	160,000.00	-	100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	730,300.00	730,200.00	100.00	99.99
210902	Хичээл үйлдвэрлэлийн дэдлага хийх	730,300.00	730,200.00	100.00	99.99
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	25,968,200.00	25,968,200.00	-	100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	25,968,200.00	25,968,200.00	-	100.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	7,000,000.00	7,000,000.00	-	100.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	18,968,200.00	18,968,200.00	-	100.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	456,978,700.00	456,111,796.34	866,903.66	99.81
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	456,978,700.00	454,764,691.14	2,214,008.86	99.52
330001	Нийгмийн даатгалын сэнгшв саяхуужих	456,978,700.00	454,764,691.14	2,214,008.86	99.52
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	1,347,105.20	(1,347,105.20)	-
350002	Туслах үйл ажлаагааны орлогоос санхүүжих	-	1,347,105.20	(1,347,105.20)	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	41,107.30	(41,107.30)	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхсийн үлдэгдэл	-	3,863.42	(3,863.42)	-
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	85	85	-	100.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.00
610001	Төсвийн байгууллага	1	1	-	100.00
610002	Төсвөөс гадуур байгууллага	-	-	-	-
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	42	42	-	100.00
620001	Удирлах ажилтан	1	1	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	33	33	-	100.00
620003	Үйлчлэх ажилтан	2	2	-	100.00
620004	Гэрээт ажилтан	6	6	-	100.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	42	42	-	100.00
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	27	27	-	100.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	15	15	-	100.00

417144353
E:0A6056 9025707

АУДИТ ХИЙГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Төлвөлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗӨӨЛИЙН ДҮН		11,346,510.00	(11,346,510.00)	
21	УРСГАЛ ЗАРДАЛ		7,646,510.00	(7,646,510.00)	
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		6,546,510.00	(6,546,510.00)	
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		4,884,260.00	(4,884,260.00)	
210101	Үндсэн цалин		4,884,260.00	(4,884,260.00)	
2104	Хангамж, бараа материалын зардал		502,250.00	(502,250.00)	
210402	Тэмдэг, шатахуун		502,250.00	(502,250.00)	
2107	Томиллолт, зочны зардал		1,000,000.00	(1,000,000.00)	
210702	Дотоод албан томиллолт		1,000,000.00	(1,000,000.00)	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		160,000.00	(160,000.00)	
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		160,000.00	(160,000.00)	
213	УРСГАЛ ШИДЖҮҮДЭГ		1,100,000.00	(1,100,000.00)	
2132	Бусад урсгал шилжүүлэг		1,100,000.00	(1,100,000.00)	
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		1,100,000.00	(1,100,000.00)	
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		3,700,000.00	(3,700,000.00)	
2200	Дотоод эх үүсвэрээр		3,700,000.00	(3,700,000.00)	
225106	Биет би биет бус хөрөнгө худалдан авсан зараал		3,700,000.00	(3,700,000.00)	
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		11,346,510.00	(11,346,510.00)	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		11,346,510.00	(11,346,510.00)	
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		3,700,000.00	(3,700,000.00)	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		7,646,510.00	(7,646,510.00)	

4417144353
 БУДА0056 902570